

ЦЭЦИЙН ШИЙДВЭРИЙН ШҮҮМЖ: АНХАН ШАТНЫ ШҮҮХ БҮРЭЛДЭХҮҮНД ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧИЙГ ОРОЛЦУУЛАХ НЬ ҮНДСЭН ХУУЛЬ ЗӨРЧӨӨГҮЙ

МУИС-ын Хууль зүйн сургуулийн дэд профессор, хууль зүйн доктор (LL.D.)
О.МӨНХСАЙХАН

Оршил¹

Монгол Улсад шударга ёсыг тогтоох, хуулийн засаглалыг бэхжүүлэх, хүний эрх, эрх чөлөөний хамгаалалтыг сайжруулах зорилгоор Шүүхийн тухай багц хуулийг Ерөнхийлөгч санаачилж, УИХ 2012 онд баталсан билээ. Эдгээр хуулиудын нэг нь Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн эрх зүйн байдлын тухай хууль (цаашид “ШИТЭЗБТХ” гэх) юм. Энэ хуулийн зорилго нь “шүүх эрх мэдлийн байгууллагад ил тод, нээлттэй байх зарчмыг бэхжүүлэх, шүүн таслах ажиллагаанд олон нийтийн зүгээс хяналт тавих тогтолцоог бий болгох” бөгөөд гол агуулга нь эрүүгийн хэрэг, эрх зүйн маргааныг анхан шатны журмаар хянан шийдвэрлэх шүүх бүрэлдэхүүнд нэг иргэдийн төлөөлөгчийг таслах эрхтэй оролцуулахыг зөвшөөрсөн явдал байсан. Энэ агуулгыг илэрхийлсэн тус хуулийн заалтууд Үндсэн хууль зөрчсөн тухай иргэний мэдээллийг Үндсэн хуулийн цэц хүлээн авч хянан хэлэлцээд 2013.11.13-нд дүгнэлт,² 2014.01.08-нд тогтоол гаргасан.³ Шүүх бүрэлдэхүүнд иргэдийн төлөөлөгчийг оролцуулах тухай заалтууд нь Үндсэн хуулийн 49.2-т буй “Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, Улсын Их Хурлын ба Засгийн газрын гишүүн, төр, нам, олон нийтийн бусад байгууллагын албан тушаалтан, иргэн хэн боловч шүүгчээс шүүн таслах үүргээ хэрэгжүүлэхэд хөндлөнгөөс оролцож болохгүй” гэсэн заалтыг зөрчсөн гэж Цэц шийдвэрлэж, тухайн заалтуудыг хүчингүй болгосон.

Үндсэн хуулийн 52.2-т “Анхан шатны шүүх хэрэг, маргааныг хамтран шийдвэрлэхдээ иргэдийн төлөөлөгчдийг хуульд заасан журмын дагуу оролцуулна” гэж заасан бөгөөд энэхүү заалтыг хоёр янзаар тайлбарлаж байна: (1) иргэдийн төлөөлөгчдийг шүүх бүрэлдэхүүнд таслах эрхтэй биш, харин шүүх хуралдаанд дүгнэлт гаргаж танилцуулах эрхтэйгээр оролцуулахыг зөвшөөрсөн; (2) хэрэг, маргааныг анхан шатны журмаар хянан шийдвэрлэх шүүх бүрэлдэхүүнд иргэдийн төлөөлөгчдийг таслах эрхтэйгээр оролцуулахыг зөвшөөрсөн. УИХ энэ хоёр тайлбарын сүүлийнхийг зөв гэж үзээд ШИТЭЗБТХ-ийг баталсан боловч Цэц энэ тайлбарыг буруу хэмээн уг хуулийн холбогдох заалтуудыг

¹ Энэхүү судалгааг хийхэд санхүүгийн болон бусад бүх дэмжлэг үзүүлсэн Нээлттэй Нийгэм Форумын хамт олонд, ялангуяа Гүйцэтгэх захирал П.Эрдэнэжаргал, Засаглалын хөтөлбөрийн менежер Б.Хишигсайхан, Хөтөлбөрийн туслах ажилтан Б.Үүрийнтуяа нарт гүн талархаж буйгаа илэрхийлж байна. Тус байгууллагаас 2014.07.01-нд энэ өгүүллээр илтгэл тавиулж, олон нийтийн хэлэлцүүлэг зохион байгуулсан юм. Мөн, энэхүү өгүүллийг дараах сэтгүүлд хэвлүүлсэн: О.Мөнхсайхан, “Цэцийн шийдвэрийн шүүмж: Анхан шатны шүүх бүрэлдэхүүнд иргэдийн төлөөлөгчийг оролцуулах нь Үндсэн хууль зөрчөөгүй,” *Шүүх эрх мэдэл: мэдээлэл, арга зүйн улирал эмхэтгэл*, №01 (2015 он), 17-32.

² УИХ э. О.Баясгалан, ҮХЦ, Дүгнэлт 04, 2013.11.13, Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем, <http://www.legalinfo.mn/law/details/9508?lawid=9508>.

³ УИХ э. О.Баясгалан, ҮХЦ, Тогтоол 01, 2014.01.08, Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем, <http://www.legalinfo.mn/law/details/9642?lawid=9642>.

хүчингүйд тооцож нэг дэх тайлбарыг зөв гэж үзсэн. Гэвч, Үндсэн хуулийн 52.2-ын талаарх нэг дэх тайлбар буруу байсан, харин хоёр дахь тайлбар зөв байсан гэдгийг энэ өгүүлэл харуулна. Тийм учраас, Цэц шүүхийн иргэдийн төлөөлөгчийн бодит оролцооны талаарх ШИТЭЗБТХ-ийн холбогдох заалтуудыг хүчингүй болгох ёсгүй байсан юм.

Үндсэн хуулийн 52.2-т иргэдийн төлөөлөгчийг оролцуулна гэж заасан боловч энэ үг ямар агуулгатай талаар тодорхой заагаагүй. Учир нь, Үндсэн хуулийн 52.2 бол “Үндсэн хуулийн цэц есөн гишүүнээс бүрдэнэ” гэсэн заалт шиг утга нь илэрхий дүрэм биш, харин хэрэг, маргаан шийдвэрлэхэд иргэдийн төлөөлөгчийг оролцуулах зарчмыг тогтоосон ерөнхий заалт юм. Үндсэн хуулийн шүүх ийм ерөнхий заалтыг тайлбарласан хэд хэдэн тайлбаруудаас үндсэн хуулийн суурь зарчим, бүтэц, түүхийг цогцоор нь утгажуулсан, хамгийн сайн үндэслэлээр дэмжигдсэн тайлбарыг зөв гэж үзэж сонгох хэрэгтэй.⁴ Үндсэн хуулийн 52.2-т иргэдийн төлөөлөгчдийг хуульд заасан журмын дагуу оролцуулна гэж заасан учраас энэ оролцоо ямар байхыг УИХ хууль тогтоох замаар шийдвэрлэхийг уг заалт зөвшөөрсөн. Мөн, иргэдийн төлөөлөгчдийг хэрэг, маргааныг анхан шатны журмаар хянан шийдвэрлэх шүүх хуралдаанд дүгнэлт гаргаж танилцуулах төдийгөөр бус харин шүүх бүрэлдэхүүнд таслах эрхтэйгээр оролцуулахыг зөвшөөрсөн гэсэн агуулгаар тайлбарлах нь иргэний шударга шүүхээр шүүлгэх үндсэн эрх болон ардчилсан ёсны зарчимд нийцсэн, илүү үндэслэлтэй тайлбар юм.

Энэ өгүүлэл нь гурван хэсгээс бүрдэнэ. 1-р хэсэгт ардчилсан орнуудад хэрэг, маргааныг анхан шатны журмаар хянан шийдвэрлэхэд иргэдийг оролцуулдаг загваруудыг товчхон судална. 2-р хэсэгт иргэдийн төлөөлөгчийг шүүх бүрэлдэхүүнд оруулахыг хүчингүй болгосон шийдвэрийн үндэслэлүүдэд дүн шинжилгээ хийж няцаах болно. 3-р хэсэгт иргэдийн төлөөлөгчдийг шүүх бүрэлдэхүүнд оролцуулах нь Үндсэн хуулийн 52.2-ын агуулга төдийгүй Үндсэн хуулийн суурь зарчмуудад нийцсэн илүү үндэслэлтэй тайлбар гэдгийг танилцуулна.

1. Хэрэг, маргаан хянан шийдвэрлэхэд иргэдийг оролцуулах загварын тухай товчхон

Энэ хэсэгт хэрэг, маргааныг хянан шийдвэрлэхэд иргэдийг оролцуулдаг хоёр үндсэн загвар болох Англи-Америкийн болон Эх газрын загваруудын агуулгыг товч танилцуулах бөгөөд ШИТЭЗБТХ-ийн гол заалтуудыг Цэцээс хүчингүй болгохоос өмнө уг хуулийн агуулга Эх газрын загвартай илүү төстэй байсан гэдгийг толилуулах болно.

Хэрэг, маргаан хянан шийдвэрлэх ажиллагаанд иргэдийг оролцуулдаг хоёр төрлийн загвар байдаг: Англи-Америкийн болон Эх газрын.⁵ Англи-Америкийн загвар нь зөвхөн мэргэжлийн бус иргэдээс бүрдсэн тангарагтны бүрэлдэхүүн (jury) байх бөгөөд уг бүрэлдэхүүнд орж буй иргэдийг тангарагтан (juror) гэдэг. Нэг бүрэлдэхүүн дэх тангарагтны

⁴ Үндсэн хуулийг тайлбарлах энэ онол, арга зүйг Үндсэн хуулийн ёс суртахууны тайлбар гэдэг бөгөөд энэ талаар зохиогчийн бичсэн дараах номоос уншина уу. Munkhsaikhan O., *Towards Better Protection of Fundamental Rights in Mongolia: Constitutional Review and Interpretation*, CALE Books 4 (Center for Asian Legal Exchange & Graduate School of Law, Nagoya University, 2014).

⁵ Anna Dobrovolskaia, “Japan’s Past Experience with the Institution of Jury Service,” *Asian-Pacific Law & Policy Journal* 12:1 (2010): 2.

тоо 6-12 байх ба тангарагтан тухайн орон нутгийн хүн амаас тохиолдлын журмаар сонгогддог. Тангарагтны бүрэлдэхүүн зөвхөн фактын асуудлыг шийдвэрлэж гэм буруутай эсхүл гэмт буруугүй гэсэн шийдвэрийг мэргэжлийн шүүгчдээс хараат бусаар гаргадаг.

Европын орнууд 18-19-р зууны үед Англи-Америкийн тангарагтны тогтолцоог хуулбарлан авсан нь одоогийн Эх газрын загварын үндэс болсон.⁶ Эх газрын загвар нь иргэн шүүгчид (lay judge - мэргэжлийн бус шүүгч) болон мэргэжлийн шүүгчдээс бүрдсэн холимог бүрэлдэхүүнийг бий болгодог бөгөөд энэхүү холимог бүрэлдэхүүн нь фактын болон хууль зүйн асуудлыг шийдвэрлэдэг. Англи-Америкийн загварт тангарагтныг зөвхөн нэг хэрэг шийдвэрлэхэд оролцуулахын тулд сонгуулийн эрх бүхий иргэдийн нэрсийн жагсаалтаас сонгодог бол Эх газрын загварт иргэн шүүгчдийн бүрэн эрхийг тодорхой хугацаагаар хэрэгжүүлэх иргэдийг орон нутгийн эрх бүхий байгууллагуудаас нэр дэвшүүлдэг. Эх газрын загвар дахь холимог бүрэлдэхүүн нь тооны хувьд янз бүр байдаг. Тухайлбал, Германд 2 иргэн шүүгч, 3 мэргэжлийн шүүгчдээс бүрдсэн бүрэлдэхүүн хүнд, онц хүнд гэмт хэргийг шийдвэрлэдэг бол 2 иргэн шүүгч, 1 мэргэжлийн шүүгчээс бүрдсэн бүрэлдэхүүн хөнгөн, хүндэвтэр гэмт хэргийг шийдвэрлэдэг. 2-3 харьцаатай холимог бүрэлдэхүүн нь шүүгдэгчийн байдлыг дордуулан бүх хэргийг дийлэнх олонх буюу 4 шүүгч санал нэгдсэнээр шийдвэрлэдэг.⁷ Өөрөөр хэлбэл, хоёр иргэн шүүгч санал нэгдвэл мэргэжлийн шүүгчдийн шийдвэрт хориг тавих боломжтой. 2-1 харьцаатай холимог бүрэлдэхүүнд иргэн шүүгчид мэргэжлийн шүүгчийн эсрэг шийдвэр гаргаж болно. Мэргэжлийн шүүгчид фактын болон хууль зүйн асуудлыг хэрхэн шийдвэрлэсэн үндэслэлийг тайлбарласан шийдвэрийг бичих үүрэгтэй.

2012 оны ШИТЭЗБТХ-аар ямар загварыг сонгосон бэ гэдгийг тодруулъя. Эрүүгийн хэрэг, эрх зүйн маргааныг анхан шатны журмаар шүүх бүрэлдэхүүнтэйгээр хянан шийдвэрлэх шүүх бүрэлдэхүүнд нэг иргэдийн төлөөлөгч оролцуулна (ШИТЭЗБТХ-ийн 12.1) гэж заасан ба энэ холимог бүрэлдэхүүн фактын болон хууль зүйн асуудлыг аль алиныг нь шийдвэрлэх байсан. Шүүхийн ерөнхий зөвлөл иргэдийн төлөөлөгчийн нэрсийн нэгдсэн жагсаалтыг хуралдаанаараа батлах бөгөөд энэ жагсаалтаас шүүх бүрэлдэхүүнд орох иргэдийн төлөөлөгчийн нэрсийг тохиолдлын журмаар тодруулахаар заасан (ШИТЭЗБТХ-ийн 8.1, 9.2, 9.3). Энэ мэтчилэн иргэдийн төлөөлөгчийг сонгон шалгаруулах, түүний үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тодорхойлох, хэрэгжүүлэхтэй холбоотой харилцааг ШИТЭЗБТХ-аар зохицуулсан байв. Шүүх бүрэлдэхүүн нэг иргэдийн төлөөлөгчтэй боловч хэдэн мэргэжлийн шүүгчийг багтаах, бүрэлдэхүүнээс гарах шийдвэр, түүний үндэслэлийг хэн бичих зэрэг бусад асуудлыг процессын хуулиудад нэмэлт өөрчлөлт оруулах замаар зохицуулахаар байсан. ШИТЭЗБТХ-ийн агуулга нь Эх газрын загвартай илүү төстэй боловч уг загвараас ялгаатай нь шүүх бүрэлдэхүүнд ганцхан иргэдийн төлөөлөгч оролцохоор тусгаж байжээ.

⁶ John H. Langbein, "Mixed Court and Jury Court: Could the Continental Alternative Fill the American Need?," *American Bar Foundation Research Journal* 195 (1981): 195.

⁷ Мөн тэнд., 199.

2. Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн талаарх Цэцийн шийдвэрт дүн шинжилгээ хийх нь

Шүүх бүрэлдэхүүнд оролцох бүрэн эрхийг иргэдийн төлөөлөгч эдэлбэл шүүгчийн хараат бус байдалд халдана (Үндсэн хуулийн 49.2-ыг зөрчинө) гэсэн агуулга бүхий дүгнэлт, тогтоолыг Цэц гаргасан боловч эдгээр шийдвэрийнхээ үндэслэл хэсэгт бичсэн өгүүлбэрүүдийн үндэслэлийг тайлбарлан бичээгүй. Гэвч, эдгээр өгүүлбэрүүдийн агуулгаас Цэцийн шийдвэрийг дэмжих гурван үндэслэл байна гэж үзэж болохоор байна: (1) шүүх бүрэлдэхүүнийг зөвхөн шүүгчид бүрдүүлэх учраас (2) шүүхийн иргэдийн төлөөлөгчийг шүүх бүрэлдэхүүнд оролцуулж байгаа нь шүүгчээс шүүн таслах үүргээ хэрэгжүүлэхэд хөндлөнгөөс оролцож буй явдал төдийгүй (3) энэ нь шүүн таслах ажиллагааны зарчмын шаардлагыг хангаж чадахгүй. Эдгээр гурван үндэслэлд хийсэн дүн шинжилгээ, тус бүр нь эсрэг үндэслэлдээ няцаагдаж байгаа талаар энэ хэсэгт харуулах болно.

2.1. Цэц: Шүүх бүрэлдэхүүн зөвхөн шүүгчдээс бүрдэнэ

Цэц анхан шатны шүүхийн шүүх бүрэлдэхүүн зөвхөн шүүгчдээс бүрдэнэ гэж үзсэн ч яагаад ингэж үзэх болсон үндэслэлээ бичээгүй, тайлбарлаагүй. Цэц дүгнэлтдээ дараах өгүүлбэрээс өөр зүйл бичээгүй байна:

1. “Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин долдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсад шүүх эрх мэдлийг гагцхүү шүүх хэрэгжүүлнэ.”, Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэгт “Бүх шатны шүүх нь Ерөнхий шүүгч, шүүгчдээс бүрдэнэ.” гэж зааснаас үзэхэд шүүхийг зөвхөн шүүгч бүрдүүлэхээр байна”⁸

Үндсэн хуулийн заалтыг Шүүхийн тухай хуулийн заалтыг биш харин Үндсэн хуулийн өөрийнх нь утгыг үндэслэн тайлбарлах хэрэгтэй. Учир нь, Цэц Үндсэн хуулийн маргаан шийдвэрлэхдээ Үндсэн хуульд захирагдах үүрэгтэй (Үндсэн хуулийн 64.2). Үндсэн хуулийн 51.1-д “Улсын дээд шүүх Ерөнхий шүүгч, шүүгчдээс бүрдэнэ” гэж заасан бол бусад шүүх зөвхөн шүүгчдээс бүрдэнэ гэж Үндсэн хуульд заагаагүй.

Хэрэг, маргааныг хамтын зарчмаар шийдвэрлэнэ гэдэг нь шүүх бүрэлдэхүүнээр шийдвэрлэнэ гэж Цэц үзсэн:

2. Үндсэн хуулийн Тавин хоёрдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Бүх шатны шүүх хэрэг, маргааныг хамтын зарчмаар хянан хэлэлцэж шийдвэрлэнэ.” гэсэн нь шүүх бүрэлдэхүүнд хамааралтай байна.”⁹

Хэрэг, маргааныг хамтын зарчмаар шийдвэрлэнэ гэдэг нь нэг шүүгч ганцаараа шийдвэрлэхгүй гэсэн утгатай. Нэг хүн бүрэлдэхүүн болохгүй бөгөөд хоёр эсхүл түүнээс дээш хүнийг бүрэлдэхүүн багтаадаг. Тиймээс, хамтын зарчмаар шийдвэрлэнэ гэдэг нь шүүх бүрэлдэхүүнээр буюу хоёр эсхүл түүнээс дээш тооны хүн хамтран шийдвэрлэнэ гэж ойлгогдож байна.

Шүүх бүрэлдэхүүнд иргэдийн төлөөлөгч орохгүй гэж Цэц дүгнэлтдээ бичжээ:

⁸ УИХ э. О.Баясгалан, ҮХЦ, Дүгнэлт 04, 2013.11.13.

⁹ Мөн тэнд.

3. Үндсэн хуулийн Тавин хоёрдугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Анхан шатны шүүх хэрэг, маргааныг хамтран шийдвэрлэхдээ иргэдийн төлөөлөгчдийг хуульд заасан журмын дагуу оролцуулна.” гэснийг иргэдийн төлөөлөгчийг шүүх бүрэлдэхүүнд оролцуулахаар заасан гэж үзэхээргүй байна.¹⁰

Иргэдийн төлөөлөгч шүүх бүрэлдэхүүнд орохгүй гэж үзэх болсон үндэслэлээ Цэц огт тайлбарлаагүй, бичээгүй. Цэцийн дүгнэлтийн үндэслэлийн 3 дахь хэсэгт бичсэн энэ утга нь Үндсэн хуулийн 52.2 дахь хэсгийг буруу тайлбарласан тайлбар гэдгийг энэ өгүүллийн 3 дахь хэсэгт харуулах болно.

2.2. Цэц: Шүүгчийн хараат бус байдалд халдана

Цэц шүүх бүрэлдэхүүнд иргэдийн төлөөлөгч орохгүй гэж үзээд зогсохгүй ийнхүү орж байгаа нь шүүгчийн хараат бус байдалд халдаж буй явдал гэжээ. Тухайлбал, Цэц тогтоолынхоо үндэслэл хэсэгт дараах зүйлийг бичсэн байна:

3. Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.3.1, мөн хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэгт иргэдийн төлөөлөгчийг шүүх бүрэлдэхүүнд оролцуулахаар зааж, шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэгч шүүхийг бүрдүүлж байгаа мэргэжлийн шүүгч мэргэжлийн үүднээс хууль хэрэглэх, эрх зүйн шийдвэр гаргах, шүүн таслах үүргээ хэрэгжүүлэхэд хөндлөнгөөс оролцож, хууль хэрэглэх, эрх зүйн шийдвэр гаргах, шүүн таслах эрхийг иргэдийн төлөөлөгчид олгосноороо Үндсэн хуулийн Дөчин есдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн заалтыг зөрчсөн гэж үзэх үндэслэлтэй байна.¹¹

Цэц энд ишилсэн байр суурийг яагаад баримтлах болсноо мөн л тайлбарлаагүй, “үндэслэлтэй байна” гэсэн боловч ямар үндэслэл байгаагаа бичээгүй. Түүнчлэн, Улсын Ерөнхий прокурор Д.Дорлигжав “Үндсэн хуулийн Дөчин есдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн агуулга нь шүүгчийн хараат бус байдлыг тунхаглан хамгаалсан хэм хэмжээ бөгөөд хуульд заасан үндэслэл журмын дагуу шүүн таслах ажиллагаанд оролцож байгаа иргэдийн төлөөлөгчийг шүүгчид хөндлөнгөөс нөлөөлж байгаа иргэн гэж үзэх боломжгүй, шүүгчтэй хамтран шүүх эрх мэдлийн үйл ажиллагаанд оролцогч иргэн гэж үзэх үндэстэй юм”¹² гэсэн тайлбарыг ирүүлсэн ч Цэц энэ тайлбарт ямар ч хариу өгөөгүй, няцаагаагүй.

Үндсэн хуулийн 49.2-ын утгыг тодорхойлохын тулд уг зүйлийг бүхэлд нь харах хэрэгтэй:

1. Шүүгч хараат бус байж, гагцхүү хуульд захирагдана.
2. Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, Улсын Их Хурлын ба Засгийн газрын гишүүн, төр, нам, олон нийтийн бусад байгууллагын албан тушаалтан, иргэн хэн боловч шүүгчээс шүүн таслах үүргээ хэрэгжүүлэхэд хөндлөнгөөс оролцож болохгүй.
3. Шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан байдлыг хангах зорилгоор Шүүхийн ерөнхий зөвлөл ажиллана.
4. Шүүхийн ерөнхий зөвлөл шүүх, шүүгчийн шүүн таслах ажиллагаанд оролцохгүйгээр, гагцхүү хуульчдаас шүүгчийг шилж олох, эрх ашгийг нь хамгаалах зэрэг шүүхийг бие даан ажиллах нөхцөлөөр хангахтай холбогдсон үүргийг биелүүлнэ.

¹⁰ Мөн тэнд.

¹¹ УИХ э. О.Баясгалан, ҮХЦ, Тогтоол 01, 2014.01.08.

¹² УИХ э. О.Баясгалан, ҮХЦ, Дүгнэлт 04, 2013.11.13.

Үндсэн хуулийн 49-р зүйл бүхэлдээ шүүгч хараат бус, шүүх бие даан ажиллах үүрэгтэйг зааж, үүний баталгааг дурдсан байна. Нэг талаас, шүүн таслах үүргээ хараат бусаар хэрэгжүүлэх үүргийг шүүгчид хүлээлгээд, нөгөө талаас шүүгчийн хараат бус байдалд хэн боловч халдаж болохгүй, үүргээ хэрэгжүүлэхэд хөндлөнгөөс оролцож болохгүй гэсэн баталгааг тогтоожээ. Юуг хөндлөнгөөс оролцсон, юуг оролцоогүй гэж үзэх вэ гэдгийг ялгаж салгах нь чухал. Аливаа этгээд (бусад шүүгч, албан тушаалтан, иргэн хэн боловч)-ээс авлига өгөх, дарамт, шахалт үзүүлэх, айлган сүрдүүлэх зэргээр шүүгчид зүй бусаар нөлөөлж болохгүй. Гэхдээ, судлаачид тодорхой шүүхийн гаргасан шийдвэрт дүн шинжилгээ хийсэн шүүмж бичих, эсхүл зөвлөлдөх тасалгаанд шүүгч бүрэлдэхүүний бусад шүүгчид тухайн маргааныг хэрхэн шийдвэрлэхтэй холбоотой үндэслэлээ хэлэх, зөвлөлдөх, дараа нь хувь хувьдаа саналаа хураалгахыг шүүгчээс шүүн таслах үүргээ хэрэгжүүлэхэд хөндлөнгөөс оролцсон, зүй бусаар нөлөөлсөнд тооцдоггүй.¹³ Үүнтэй нэгэн адилаар шүүхийн иргэдийн төлөөлөгч мэргэжлийн шүүгчтэй хамт нэг шүүх бүрэлдэхүүнд ороод хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх шүүх хуралдаанд оролцож, асуулт асууж, зөвлөлдөх тасалгаанд хууль зүйн болон фактын асуудлыг хэрхэн шийдвэрлэх талаарх үндэслэлээ хэлж, зөвлөлдөж, бие даан саналаа өгөхийг шүүгчийн хараат бус байдалд халдсанд тооцохгүй. Шүүх бүрэлдэхүүнд орсон иргэдийн төлөөлөгч ч бай, мэргэжлийн шүүгч ч бай бие биеийнхээ хараат бус байдлыг харилцан хүндэтгэх үүрэгтэй. Хэрэв иргэдийн төлөөлөгч шүүгчтэй нэг шүүх бүрэлдэхүүнд орж хэрэг, маргааныг шийдвэрлэхийг шүүгчээс албан үүргээ хэрэгжүүлэхэд хөндлөнгөөс оролцсон гэж үзвэл ХБНГУ, Австри, Дани, Франц, Грек, Итали, Португали, Япон зэрэг холимог бүрэлдэхүүнээр хэрэг, маргааныг шийдвэрлэдэг улсуудад шүүгчид нь мөн адил нөхцөлд байдаг, хараат бус байдал нь хангагдаагүй гэж үзэх ёстой болно. Түүнчлэн, фактын асуудлыг тангарагтнууд буюу иргэдээр таслуулж, хууль зүйн асуудлыг мэргэжлийн шүүгч шийдвэрлэдэг Англи-Америкийн загвартай улсуудын шүүгчдийг тангарагтнуудаас хараат гэж үзэх үү гэдэг асуудал гарч ирнэ. Гэтэл, Эх газрын болон Англи-Америкийн загвар бүхий эдгээр улсуудад шүүгчийн хараат бус байдал хангагдсан, баталгаажсан бөгөөд эрх зүйт ёс өндөр түвшинд бэхэжсэн гэж үнэлдэг.¹⁴

2.3. Цэц: Шүүн таслах ажиллагааны зарчмын шаардлагыг хангахгүй

УИХ-ын итгэмжлэгдсэн төлөөлөгч “Иргэдийн төлөөлөгчийн оролцоо мөн мэргэжлийн боловсролгүй энгийн иргэд ч тухайн нийгэмдээ зөв буруу, шударга, шударга бусыг таньж ойлгох чадавхтай болохыг илэрхийлдэг”¹⁵ гэсэн тайлбарыг өгсөн ч Цэц энэ тайлбараас татгалзаж, тогтоолынхоо үндэслэл хэсэгт дараахыг бичжээ:

“2. Иргэдийн төлөөлөгчийг шүүх бүрэлдэхүүнд оролцуулахаар хуульчилсан нь хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэх, шүүн таслах

¹³ Peter H. Russell and David M. O'Brien, *Judicial Independence in the Age of Democracy: Critical Perspectives from Around* (Charlottesville: University of Virginia Press, 2001), 11–12.

¹⁴ “The Rule of Law Index 2014 Report | The World Justice Project,” March 5, 2014, <http://worldjusticeproject.org/publication/rule-law-index-reports/rule-law-index-2014-report>.

¹⁵ УИХ э. О.Баясгалан, YXЦ, Тогтоол 01, 2014.01.08.

ажиллагааны хуулиар тогтоосон зарчмын шаардлагыг хангах нөхцөл болж чадахгүй байна.”¹⁶

Цэц яагаад ингэж үзэж байгаагаа огт тайлбарлаагүй, үндэслэлээ бичээгүй. Гэхдээ, Цэцийн хэлэх гэсэн санааг дараах байдлаар тодруулъя:

Мэргэжлийн шүүгч хууль зүйн мэдлэг, ур чадвар, туршлагатай учраас нотлох баримтыг зөв үнэлж хуулийг зөв хэрэглэж зөв шийдвэр гаргах чадвартай бол хуульчийн мэргэжилгүй жирийн иргэдэд ийм мэдлэг, ур чадвар, туршлага байхгүй. Жирийн иргэд хууль зүйн хэцүү ойлголтуудыг ойлгож хэрэглэж чадахгүй. Тиймээс, иргэдийн төлөөлөгчийг шүүх бүрэлдэхүүнд оруулбал шүүхийн шийдвэр алдаатай гарч, хүний эрх, эрх чөлөө зөрчигдөх, хянан шийдвэрлэх ажиллагаа хуульд заасан зарчмын дагуу явагдахгүй байх эрсдэлтэй.

Иргэдийг хэрэг, маргаан хянан шийдвэрлэх ажиллагаанд бодитойгоор оролцуулахыг эсэргүүцдэг хүмүүс ийм шүүмжлэл гаргадаг ч энэ нь сайн үндэслэлээр дэмжигддэггүй.

Англи-Америкийн загварт фактын асуудлыг тангарагтны бүрэлдэхүүн бүрэн шийдвэрлэдэг. Олон арван жил системтэйгээр цуглуулсан мэдээлэл, судалгаа нь тангарагтан үүргээ биелүүлж чаддаг, шүүхийн тогтолцоо дахь иргэдийн оролцооны давуу талуудыг нотолдог.¹⁷ Тангарагтан хууль зүйн тогтолцооны талаар илүү сайн ойлголттой болж ач холбогдлыг нь мэдээд зогсохгүй тангарагтны үүргээ гүйцэтгэснийхээ дараа олон нийтийн үйл ажиллагаанд илүү идэвхтэй оролцох хандлагатай байдаг.¹⁸ Тангарагтнууд хамтдаа зөвлөлдөж шийдвэр гаргадаг учраас нотлох баримтыг нэг хувь хүнээс илүү сайн тайлбарлаж, хувийн явцуу үзэл, ашиг сонирхол, ялгаварлан гадуурхах хандлагаа даван туулж чаддаг бөгөөд хэцүү хэргүүдийг шийдвэрлэхэд мэргэжлийн шүүгчид тангарагтнуудаас илүү биш гэдгийг судалгаа харуулдаг.¹⁹

XVII-XIX зууны үед эх газрын Европчууд Англи-Америкийн тангарагтны тогтолцоог авахдаа түүний дутагдалтай талыг нөхөж, сайжруулан нутагшуулсан гэж үздэг. Холимог шүүх бүрэлдэхүүн нь хуульчийн мэргэжилгүй иргэн шүүгчдийн туршлагагүй байдлын эсрэг гурван янзын хамгаалалтыг хөгжүүлсэн: (1) иргэн шүүгчид мэргэжлийн шүүгчидтэй хамт зөвлөлдөж шийдвэр гаргадаг; (2) холимог бүрэлдэхүүнээс үндэслэлээ тайлбарласан шийдвэр гаргахыг шаарддаг; (3) давж заалдах өргөн боломж олгодог. Зөвлөлдөх тасалгаанд мэргэжлийн шүүгчид хуулийн нарийн ойлголтуудыг иргэн шүүгчид тайлбарлаж өгөх, хууль зүйн болон фактын асуудал дээр алдаа гаргахаар бол анхааруулах боломжтой. “Шүүгчид [хууль ёсны болон шударга ёсны хувьд илүү сайн үндэслэлүүдээр] итгүүлэн үнэмшүүлэх замаар иргэн шүүгчдийн хүлээцгүй эсхүл мэдлэггүй байдлаас үүдэн шударга бус үр дүн гарахаас сэргийлж чаддаг.”²⁰ Мэргэжлийн шүүгчид зөвлөлдөөнд

¹⁶ Мөн тэнд.

¹⁷ Matthew Wilson, “Benefits of Adopting Civil Jury Trials in Japan and Lessons from the United States,” May 30, 2013, 19, http://papers.ssrn.com/sol3/papers.cfm?abstract_id=2272119; Neil Vidmar and Valerie P. Hans, *American Juries: The Verdict* (Amherst, N.Y.: Prometheus Books, 2007), 153–168; Roscoe Pound Institute, “The Jury as Fact Finder and Community Presence in Civil Justice: Report of the 2001 Forum for State Appellate Court Judges,” 2005, 7.

¹⁸ Roscoe Pound Institute, “The Jury as Fact Finder and Community Presence in Civil Justice: Report of the 2001 Forum for State Appellate Court Judges,” 138.

¹⁹ Wilson, “Benefits of Adopting Civil Jury Trials in Japan and Lessons from the United States,” 19–22.

²⁰ Langbein, “Mixed Court and Jury Court: Could the Continental Alternative Fill the American Need?,” 205.

оролцдог учраас шийдвэр, түүний үндэслэлээ бичгээр гаргах ёстой. Фактыг хэрхэн тодорхойлсон, хуулийг хэрхэн хэрэглэсэн талаар шийдвэртээ бичдэг. “Мэргэжлийн шүүгчид өөрсдийн бичиж буй шийдвэртээ тухайн шийдвэрийн алдаатай үндэслэлүүдийг бичих үүрэгтэй”²¹ бөгөөд уг шийдвэрт давж заалдах боломжтой. Хамтын зарчмаар шийдвэрлэдэг нь шүүхийн дур зорго, алдаанаас сэргийлэх нэг механизм болдог учир нь хэд хэдэн мэргэжлийн шүүгчид иргэн шүүгчидтэй нэг бүрэлдэхүүнд оролцдог (ихэнхдээ 1-3 мэргэжлийн шүүгч 2-9 иргэн шүүгчтэй нэг бүрэлдэхүүнд ордог²²). Энэ бүхэн нь алдаатай эсхүл тодорхойгүй шийдвэр гарахаас урьдчилан сэргийлдэг байна.

Ардчилал, хуулийн засаглалыг бэхжүүлэхийн төлөө хууль зүйн тогтолцоогоо шинэчилж байгаа Япон, Солонгос зэрэг улсууд Англи-Америкийн болон Эх газрын загваруудын аль алины шинжийг агуулсан (эсхүл аль нэг нь давамгайлсан) иргэдийн оролцооны тогтолцоог нутагшуулан авч байна. Япон, Солонгост хэрэг, маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа дахь иргэдийн оролцоог хуульчлах үед иргэд хэрэг, маргааныг хянан шийдвэрлэхэд шаардлагатай мэдлэг, ур чадвараар дутаж алдаа их гаргах байх гэсэн болгоомжлол байсан ч энэ болгоомжлол нь бодитой биш байсан төдийгүй энэ шинэ тогтолцоо нь олон эерэг өөрчлөлт, хандлагыг бий болгож байна.²³

3. Шүүх бүрэлдэхүүнд иргэдийн төлөөлөгчийг оролцуулах нь Үндсэн хууль зөрчөөгүй тухай үндэслэл

Иргэдийн төлөөлөгчийг шүүх бүрэлдэхүүнд оролцуулах нь Үндсэн хууль зөрчсөн эсэх асуудлыг шийдвэрлэхдээ Цэц уг асуудлыг шууд зохицуулсан Үндсэн хуулийн заалт (52.2)-ыг тайлбарлах ёстой байсан боловч тэгээгүй. Тиймээс, энэ хэсэгт Үндсэн хуулийн 52.2-ын агуулгыг тайлбарлаж, уг тайлбар нь тухайн зүйлийн агуулгаар төдийгүй Үндсэн хуулийн суурь зарчмууд (шударга шүүхээр шүүлгэх эрх болон ардчилсан ёс)-аар зөвтгөгдөж байгаа тухай танилцуулна.

3.1. Үндсэн хуулийн 52.2-ыг тайлбарлах нь

Үндсэн хуулийн 52.2-ын утгыг зөв тайлбарлахын тулд Үндсэн хуулийн 52-р зүйлийг бүхэлд нь унших шаардлагатай:

1. Бүх шатны шүүх хэрэг, маргааныг хамтын зарчмаар хянан хэлэлцэж шийдвэрлэнэ.
2. Анхан шатны шүүх хэрэг, маргааныг хамтран шийдвэрлэхдээ иргэдийн төлөөлөгчдийг хуульд заасан журмын дагуу оролцуулна.

²¹ Мөн тэнд., 213.

²² Ethan J. Leib, “A Comparison of Criminal Jury Decision Rules in Democratic Countries,” *Ohio State Journal of Criminal Law* 5:629.

²³ Wilson, “Benefits of Adopting Civil Jury Trials in Japan and Lessons from the United States,” 7–11; Sang Hoon Han and Kwangbai Park, “Citizen Participation in Criminal Trials of Korea: A Statistical Portrait of the First Four Years,” 2012, <http://people.ucsc.edu/~hfukurai/documents/2-Han-Park.pdf>; Jae-Hyup Lee, “Korean Jury Trial: Has the New System Brought About Changes?,” *Asian-Pacific Law & Policy Journal* 12 (2010): 58.

3. Хуульд тусгайлан зүйлчилж заасан зарим хэргийг шүүгч дангаар хянан шийдвэрлэж болно.

Энэ зүйл нь бүх шатны шүүх хэрэг, маргааныг хамтын зарчмаар буюу бүрэлдэхүүнээр хянан хэлэлцэж шийдвэрлэнэ, гэхдээ хуульд тусгайлан заасан бол зарим хэргийг шүүгч дангаар хянан шийдвэрлэнэ гэсэн утгатай байна. Учир нь, хамтын зарчмаар шийдвэрлэнэ гэдгийг шүүх бүрэлдэхүүнээр шийдвэрлэнэ гэсэн утгаар хуулийн практикт ойлгодог. Үндсэн хуулийн 52.1-д бүх шатны шүүхэд хэрэгжих хамтын зарчмын талаар ерөнхийд нь заасан бол 52.2-т анхан шатны шүүхэд хамтын зарчим хэрхэн хэрэгжих талаар тусгайлан зохицуулжээ. Өөрөөр хэлбэл, анхан шатны шүүх хэрэг, маргааныг шийдвэрлэх бүрэлдэхүүндээ иргэдийн төлөөлөгчийг хуульд заасан журмаар (таслах эрхтэйгээр) оролцуулна. Тийм ч учраас Үндсэн хуулийн 52.1 болон 52.2-т “хамтын зарчим” болон “хамтран” гэсэн адилхан утгатай үгнүүд хэрэглэсэн. Хувь иргэний төдийгүй нийт иргэний эрхэд нөлөөлөх асуудлаар заавал биелэгдэх шийдвэр гаргадаг хянан шийдвэрлэх ажиллагаанд иргэд таслах эрхтэйгээр оролцож байгаа нь шийдвэр гаргах процесст бодитой оролцож байгаа нэг хэлбэр.

Үндсэн хуулийн 52.2-т “Анхан шатны шүүх хэрэг, маргааныг хамтран шийдвэрлэхдээ иргэдийн төлөөлөгчдийг хуульд заасан журмын дагуу оролцуулна” гэж заасан бөгөөд иргэдийн төлөөлөгч оролцох асуудлыг шийдвэрлэх бүрэн эрхийг УИХ-д Үндсэн хуулиар өгсөн байна. Энэ заалтын дагуу УИХ-аас ШИТЭЗБТХ-ийг баталсан. УИХ-ын итгэмжлэгдсэн төлөөлөгч тайлбартаа “Эндээс бид Үндсэн хууль иргэдийн төлөөлөгчдийг хэрхэн оролцуулахыг тогтоохыг хууль тогтоогчдод үлдээжээ гэдгийг харж болно”²⁴ гэж бичсэн боловч Цэц энэ үндэслэлд ямар ч хариу өгөөгүй. Үндсэн хуулийн 52.2 болон бусад зүйлүүдэд “хуульд заасан журмын дагуу,” “хуульд заасан үндэслэлээр (Үндсэн хуулийн 5.3),” “хуульд тусгайлан зааснаас бусад тохиолдолд (Үндсэн хуулийн 54.1),” “хуулиар тогтооно (Үндсэн хуулийн 49.5)” зэргээр УИХ хууль тогтоож шийдвэрлэх асуудлуудыг заасан. Эдгээр асуудлын хүрээнд УИХ-аас баталсан хууль хүний эрх, эрх чөлөө болон Үндсэн хуулийн бусад суурь зарчмыг зөрчсөн нь хангалттай үндэслэлээр нотлогдсоноос бусад тохиолдолд Цэц тухайн хуулийг хүчингүй болгох бүрэн эрхгүй. Учир нь, эдгээр асуудлыг хууль тогтоож шийдвэрлэх бүрэн эрхийг Үндсэн хуулиар тусгайлан УИХ-д өгсөн бөгөөд Цэц УИХ-ын энэ бүрэн эрхэд халдаж болохгүй.

Шүүх бүрэлдэхүүнд орох иргэдийн төлөөлөгчийн бүрэн эрхийг зөвшөөрсөн агуулга бүхий ШИТЭЗБТХ нь Үндсэн хуулийн 52.2-д нийцээд зогсохгүй Үндсэн хуулийн өөр хоёр суурь зарчмаар зөвтгөгдөж байна: (1) иргэдийн шударга шүүхээр шүүлгэх эрхийг баталгаажуулах болон (2) ардчилсан ёсыг хангахын тулд шүүхийн иргэдийн төлөөлөгчийг шүүх бүрэлдэхүүнд оруулах шаардлагатай. УИХ-ын итгэмжлэгдсэн төлөөлөгч энэ хоёр үндэслэлтэй адилхан санааг тайлбарлан бичсэн боловч Цэц үүнд ямар ч хариу өгөөгүй байна.²⁵

3.2. Шударга шүүхээр шүүлгэх эрхийг баталгаажуулах

Иргэдийн төлөөлөгчийг шүүх бүрэлдэхүүнд оролцуулах нь шударга шүүхээр шүүлгэх

²⁴ УИХ э. О.Баясгалан, ҮХЦ, Тогтоол 01, 2014.01.08.

²⁵ Мөн тэнд.

иргэний эрхийг хангах нэг механизм мөн. АНУ-ын Үндсэн хуулийн 6-р нэмэлт өөрчлөлт “Бүх гэмт хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд яллагдагч нь төвийг сахисан тангарагтны бүрэлдэхүүнээр шүүлгэх эрхтэй” гэж заасан. Монгол Улсын Үндсэн хуулийн 16-р зүйлд үүнтэй төстэй боловч илүү өргөн агуулгатай эрх болох “шударга шүүхээр шүүлгэх” иргэний эрхийг баталгаажуулсан. Шударга шүүхээр шүүлгэх эрх нь мэргэжлийн шүүгч болон иргэдийн төлөөлөгчийг оролцуулсан холимог шүүх бүрэлдэхүүнээр хэрэг, маргаанаа шийдвэрлүүлэх эрхийг багтаадаг. Учир нь, холимог шүүх бүрэлдэхүүн илүү шударга шийдвэр гаргах магадлалтай. Шударга ёс гэдэг бол зөвхөн хуульчдын мэддэг, өмчилдөг зүйл биш харин нийгмийн ойлголт бөгөөд тухайн нотлох баримт болон хуулийн агуулгыг ойлгогдохуйц тайлбарлагдсан тохиолдолд жирийн ухаалаг иргэн аль нь шударга, зөв бэ гэдгийг ялгаж салгах чадвартай. “Англид шүүхийн процессын хүлээн зөвшөөрөгдөх байдлыг хангахын тулд тангарагтны бүрэлдэхүүнийг анх ажиллуулж эхэлсэн бөгөөд үүний шалтгаан нь мэргэжлийн бус олон нийт илүү шударга шийдвэр гаргана гэж үзэж байсантай холбоотой.”²⁶ Туршлага болон үзэл бодлын ялгаатай байдал нь тангарагтнуудыг өрсөлдөгч тайлбаруудыг нухацтайгаар бодох, зөвлөлдөх, анхаарч үзэх, улмаар агуулгын хувьд шударга шийдвэр гаргахад хүргэх хандлагатай.²⁷ АНУ-ын тангарагтны бүрэлдэхүүний шийдвэрүүдийг судалсан судлаачид тангарагтны бүрэлдэхүүний шийдвэр нь нотлох баримтад илүү сайн тулгуурлах хандлагатай байдаг гэж дүгнэжээ.²⁸

Иргэдийн төлөөлөгчид нь асуудал бүрт анхаарлаа илүү сайн хандуулах хандлагатай. Тодорхой хэмжээний мэдлэггүй байдал нь хэрэг, маргаан хянан шийдвэрлэх ажиллагаанд чухал үүрэгтэй. Хууль зүйн боловсролгүй, туршлагагүй иргэдийг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцуулах нь эерэг үр дагаврыг бий болгодог. Жишээлбэл, мэргэжлийн бус хүмүүс шинэ зүйлд илүү мэдрэмжтэй ханддаг. “Гэмт хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд олон жил ажилласан туршлагатай мэргэжлийн шүүгчид үл тоомсорлох хандлагатай болчих талтай. Гэмт хэрэгт холбогдолгүй гэсэн нотолгоог урьд өмнө олон зуун удаа сонсож байгаагүй учраас иргэд тодорхой тохиолдлууд дахь үнэн нотолгоог олж харахдаа илүү сэргэг байх магадлалтай.”²⁹

Хэрэг, маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа нь хууль болон нотлох баримтад тулгуулан явагдаж шударга, төвийг сахисан шийдвэр гаргах баталгааг хангахын тулд шүүгчийн хараат бус байдлыг баталгаажуулах шаардлагатай боловч шүүгчийн дур зоргыг хязгаарлах механизм хэрэгтэй. АНУ-ын тангарагтны бүрэлдэхүүн болон Европын холимог шүүх бүрэлдэхүүн нь авлигад автсан, хэтэрхий улайрсан прокуророос эсхүл аль нэг талд тал зассан, ёс зүйгүй шүүгчдээс яллагдагчийг хамгаалах зорилгоор анх бий болсон

²⁶ Wilson, “Benefits of Adopting Civil Jury Trials in Japan and Lessons from the United States,” 33.

²⁷ Phoebe Ellsworth, “Are Twelve Heads Better Than One?,” *Law and Contemporary Problems* 52, no. 4 (October 1, 1989): 206.

²⁸ Ерөнхийд нь дараах бүтээлүүдээс харна уу: Harry Kalven Jr and Hans Zeisel, *The American Jury* (Chicago: University of Chicago Press, 1971); Theodore Eisenberg et al., “Judge-Jury Agreement in Criminal Cases: A Partial Replication of Kalven and Zeisel’s *The American Jury*,” *Cornell Law Faculty Publications*, March 1, 2005, <http://scholarship.law.cornell.edu/facpub/343>; Valerie Hans et al., “The Hung Jury: The American Jury’s Insights and Contemporary Understanding,” *Crim. L. Bull.* 39 (2003): 33.

²⁹ Langbein, “Mixed Court and Jury Court: Could the Continental Alternative Fill the American Need?,” 211.

байна.³⁰ Өөрөөр хэлбэл, хянан шийдвэрлэх ажиллагаа дахь иргэдийн бодит оролцоо нь шүүх эрх мэдлийг урвуулан ашиглахаас урьдчилан сэргийлэх төдийгүй төрөөс томилогдсон шүүгчид эргээд төрөөсөө хараат бус ажиллаж чадах уу гэсэн эргэлзээг арилгахын тулд үүсжээ.³¹ Орчин үеийн хэллэгээр, авлигатай тэмцэх арга хэрэгсэл болгож тангарагтны бүрэлдэхүүнийг анх танилцуулсан гэж хэлж болно. Иргэдийн төлөөлөгчийг хэрэг, маргаан шийдвэрлэхэд таслах эрхтэйгээр оролцуулах нь Монгол Улсад эрх зүйт ёсыг бэхжүүлэх, шүүх эрх мэдэл дэх авилгийг багасгах хамгийн сайн арга болох тухай Брент Вайт нэлээд дэлгэрэнгүй бичжээ.³²

Иргэдийн оролцоо нь шүүх эрх мэдлийг урвуулан ашиглаж, аливаа дарамт, нөлөө ирж буй эсэхэд тавих олон нийтийн хараат бус хяналт болох бөгөөд мэргэжлийн шүүгчдэд төрийн байгууллага, албан тушаалтнаас нөлөөлөх боломжийг багасгадаг. Тангарагтны бүрэлдэхүүн эсхүл холимог шүүх бүрэлдэхүүн нь олон тооны гишүүдээс бүрддэг учраас авлига болон бусад зүй бус нөлөөнд өртөх нь бага ажээ. Түүнчлэн, хуульчийн мэргэжилгүй иргэд харьцангуй хараат бус байх боломж өндөр байдаг. Мэргэжлийн бус хүмүүсийн амьдрал нь мэргэжлийн шүүгчдийг томилдог эрх мэдэлтнүүдийн шийдвэрээс шууд хамаардаггүй. Мэргэжлийн шүүгчид дээд шатны шүүх рүү эсхүл ерөнхий шүүгчээр томилогдох, хөдөө орон нутгаас Улаанбаатар хот руу томилогдох зэрэг мэргэжлийн хувьд өсөж дэвжих ашиг сонирхолтой байдаг нь тэднийг томилох эрх бүхий байгууллага, албан тушаалтнуудын зүй бус нөлөөнд орох эрсдэлийг үүсгэдэг. Харин, иргэн шүүгчид ийм ашиг сонирхолгүй, төрөөс хамааралгүй учраас хэрэг, маргаан хянан шийдвэрлэх ажиллагааг санаатайгаар урвуулан ашиглах, зүй бус нөлөөнд автахгүйгээр шийдвэр гаргах чадвартай.³³ Мэргэжлийн бус хүмүүс шүүх бүрэлдэхүүнд орсноороо мэргэжлийн шүүгчид улс төрийн асуудал дээр дуулгавартай хандах болон дур зоргын шийдвэр гаргахаас урьдчилан сэргийлдэг байна.³⁴

3.3. Ардчилсан ёсыг хангах

Хэрэг, маргааныг анхан шатны журмаар шийдвэрлэхэд иргэдийн төлөөлөгч оролцох нь ардчилсан ёсыг хангана. Учир нь, иргэд нийтийн ашиг сонирхлыг хөндсөн асуудлуудыг шийдвэрлэхэд таслах эрхтэй оролцохын зэрэгцээ төрийн эрх мэдлийн нэг салаа болох шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэх ажиллагаа иргэдэд илүү ойлгомжтой, хүлээн зөвшөөрөгдөхүйц болж, иргэдийн шүүхэд итгэх итгэл нэмэгддэг.

Ардчилсан улсад төрийг удирдах хэрэгт иргэд олон янзаар оролцдог. Монгол Улсын Үндсэн хуулийн 3.1-д “Монгол Улсад засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна,” “Монголын ард түмэн төрийн үйл хэрэгт шууд оролцож, мөн сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан энэхүү эрхээ эдэлнэ,” мөн 16.9-д “шууд буюу төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан төрийг удирдах хэрэгт оролцох эрхтэй,”

³⁰ Мөн тэнд., 209.

³¹ Wilson, “Benefits of Adopting Civil Jury Trials in Japan and Lessons from the United States,” 16.

³² Brent T. White, *Putting Aside the Rule of Law Myth: Corruption and the Case for Juries in Emerging Democracies*, SSRN Scholarly Paper (Rochester, NY: Social Science Research Network, March 13, 2009), 63, <http://papers.ssrn.com/abstract=1359338>.

³³ Wilson, “Benefits of Adopting Civil Jury Trials in Japan and Lessons from the United States,” 25.

³⁴ Langbein, “Mixed Court and Jury Court: Could the Continental Alternative Fill the American Need?,” 205.

“Төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхтэй” гэж тус тус заасан. Иргэдийн төлөөлөгчдийн байгууллага буюу УИХ, ИТХ-аар уламжлан төрийг удирдах хэрэгт иргэд оролцдог. Төрийг удирдахад шууд оролцох янз бүрийн хэлбэр байж болох бөгөөд Үндсэн хуулиар заримыг нь зааж өгсөн. Тухайлбал, баг, хорооны иргэдийн нийтийн хуралд иргэд шууд оролцож, шийдвэр гаргахад саналаа өгөх эрхтэй (Үндсэн хуулийн 59.2). Мөн, иргэд Үндсэн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах болон бусад асуудлаар зохих журмын дагуу явуулж байгаа санал асуулгад оролцож саналаа өгөх эрхтэй (Үндсэн хуулийн 25.1.16 болон 68.2).

Төрийг удирдах хэрэгт шууд оролцох иргэний эрхийг эдлэх нэг хэлбэр бол хуульд заасны дагуу анхан шатны журмаар хэрэг, маргааныг шүүхээр шийдвэрлэхэд таслах эрхтэй оролцох явдал юм. Уул уурхайн компани болон малчдын хооронд үүсэж байгаа маргаан, бэлчээрийн сүйтгэл, байгал орчны бохирдол, усны хомсдол зэрэг нийтийн ашиг сонирхлыг хөндсөн олон асуудлуудыг шүүхээр шийдвэрлэхэд иргэд таслах эрхтэй оролцохыг Үндсэн хуулийн 52.2 зөвшөөрсөн. “Иргэд улс төрийн асуудлыг шийдвэрлэхийн тулд нүүр нүүрээ харж байгаад мэтгэлцэх, түүнд оролцох нь иргэний оролцоог жинхэнэ утгаар дэмждэг.”³⁵ Түүнчлэн, иргэд шүүн таслах ажиллагаанд оролцсоноор иргэдийн талаас асуудлыг илүү харах, үндэслэл гаргах хандлагатай. Тиймээс, нийтийн ашиг сонирхолтой холбоотой асуудлуудыг шийдвэрлэсэн шийдвэр нь жирийн иргэдийн үнэт зүйлд илүү ойрхон болдог байна.³⁶

Шүүхийн шийдвэр болон процесс иргэдэд илүү ойлгомжтой болно. Шийдвэр гаргахад иргэдийн төлөөлөгч таслах эрхтэй оролцох учраас мэргэжлийн шүүгчид шүүх процесс, хууль зүйн ойлголтыг жирийн иргэн хүлээн авахуйцаар тайлбарлаж өгөхөөс гадна шүүхийн шийдвэрийнхээ үндэслэлийг аль болох ойлгогдохуйц хэллэгээр бичихийг чармайдаг. Мөн, хэрэг, маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа иргэдэд илүү ойлгомжтой болоход тустай. “Процесс болон материаллаг хэм хэмжээ нь жирийн иргэдэд илүү ойлгомжтой байх ёстой тохиолдолд хууль илүү энгийн болох, иргэдэд [хуулийн талаар илүү] сайн ойлголт өгч, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх эрүүгийн эрх зүйн зорилгод хувь нэмэр оруулдаг.”³⁷ Иргэдийн төлөөлөгч шүүх бүрэлдэхүүнд ордог болсон тохиолдолд өмгөөлөгч, прокурор хэрэг, маргааны нотлох баримт, хууль зүйн үндэслэлийг гаргаж тавихдаа иргэдийн төлөөлөгчдөд илүү ойлгомжтой тайлбарлаж, мэргэжлийн жаргон (этгээд үг), сунжирсан ойлгомжгүй хэллэгээс татгалзаж илүү энгийн, тодорхой хэллэгээр ярьдаг болно. Жишээ нь, Япон манайхтай төстэй Эх газрын загварыг 2009 онд нэвтрүүлсэн бөгөөд үүнтэй холбоотойгоор хуульчид илтгэх чадвар иргэд рүү чиглэсэн, ойлгомжтой болж хөгжиж байна. Японы хуульчид шүүх хурал дээр Power Point, үзүүлэн хүртэл ашигладаг болсон нь үүний нэг илрэл. Нөгөө талаас, АНУ, Европын улсууд болон Япон, Солонгос зэрэг улсуудад тангарагтан болон иргэн шүүгчид зориулсан сургалт зохион байгуулах, ном, товхимол хэвлэж тараах, телевизийн нэвтрүүлэг бэлтгэх, сурталчлах зэрэг ажлыг тогтмол хийдэг.

³⁵ John Gastil, E. Pierre Deess, and Phil Weiser, “Civic Awakening in the Jury Room: A Test of the Connection Between Jury Deliberation and Political Participation,” *The Journal of Politics* 64, no. 02 (2002): 591–592, doi:10.1111/1468-2508.00141.

³⁶ White, *Putting Aside the Rule of Law Myth*, 64–65.

³⁷ Langbein, “Mixed Court and Jury Court: Could the Continental Alternative Fill the American Need?,” 211.

Иргэдийн төлөөлөгчийн бодит оролцоо нь иргэний эрх зүйн боловсролыг нэмэгдүүлнэ. Иргэд шүүх хуралдаанд таслах эрхтэй оролцсоноор ардчилсан нийгмийн нэг чухал институт болох шүүх процессыг илүү сайн ойлгож, хууль зүйн боловсрол нь дээшилдэг. Хэрэг, маргааныг шийдвэрлэх гэдэг бол фактыг нотлох баримтад тулгуурлан тогтоож хууль хэрэглэн шийдвэрлэдэг нарийн, амаргүй ажиллагаа гэдгийг иргэд нүдээрээ харж бас талуудын хуульчдын, мэргэжлийн шүүгчдийн тайлбараас ойлгож авна, ингэснээр шүүх эрх мэдэлд итгэх итгэл нэмэгдэнэ. Шүүхийн иргэдийн төлөөлөгчөөр ажилласныхаа дараа иргэд нийгмийн амьдралд илүү идэвхтэй оролцох хүсэл эрмэлзэлтэй болох төдийгүй өөрийнх нь эрх зөрчигдвөл шүүхэд хандах наад захын мэдлэгтэй болно. Тиймээс, шүүхийн иргэдийн төлөөлөгч бол иргэний боловсрол олгох маш чухал механизм.

Дүгнэлт

Шүүх эрх мэдлийн шинэтгэлийн хүрээнд 2012 онд батлагдсан Шүүхийн тухай багц хуулиудын нэг нь Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн эрх зүйн байдлын тухай хууль. Хэрэг, маргааныг анхан шатны журмаар хянан шийдвэрлэх шүүх бүрэлдэхүүнд оролцох бүрэн эрхийг шүүхийн иргэдийн төлөөлөгчид өгсөн нь энэ хуулийн зарчмын шинэлэг тал байсан. ШИТЭЗБТХ-ийг батлахдаа УИХ иргэдийн төлөөлөгч мэргэжлийн шүүгчтэй хамт нэг бүрэлдэхүүнд орж анхан шатны журмаар хэрэг, маргааны хууль зүйн болон фактын асуудлыг аль алиныг нь шийдвэрлэх тогтолцоог нэвтрүүлэхийг зорьсон. Энэ тогтолцоо нь Америк-Английн биш Эх газрын загварт тулгуурлаж байсан юм (гэхдээ, Эх газрын загвараас ялгаатай нь нэг иргэдийн төлөөлөгч хоёр мэргэжлийн шүүгчтэй хамт нэг шүүх бүрэлдэхүүнд орох байсан). Шүүхэд хэрэг, маргаан хянан шийдвэрлэхэд иргэдээ таслах эрхтэйгээр оролцуулдаг нийтлэг чиг хандлага ардчилсан улсуудад байна.³⁸

Иргэдийн төлөөлөгч мэргэжлийн шүүгчтэй хамт нэг бүрэлдэхүүнд орж анхан шатны журмаар хэрэг, маргааны хууль зүйн болон фактын асуудлыг шийдвэрлэхэд таслах эрхтэй оролцох тухай хуулийн заалтуудын талаарх иргэний мэдээллийг Үндсэн хуулийн цэц хүлээн авч хянан хэлэлцээд, эдгээр заалтуудыг Үндсэн хуулийн 49.2-ыг зөрчсөн буюу шүүгчийн хараат бус байдалд халдсан гэж үзээд хүчингүй болгож шийдвэрлэсэн. Шүүх бүрэлдэхүүнд шүүхийн иргэдийн төлөөлөгч оролцохыг Үндсэн хуулиар зөвшөөрөөгүй учир ийнхүү оролцуулахыг зөвшөөрсөн зохицуулалт нь шүүгчээс шүүн таслах үүргээ хэрэгжүүлэхэд иргэд хөндлөнгөөс оролцох боломжийг нээсэн бөгөөд иргэдийн төлөөлөгч шүүх бүрэлдэхүүнд орж байгаа нь хүний эрхийг хамгаалах, шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэх, шүүн таслах ажиллагааны зарчмын шаардлагыг хангах нөхцөл болохгүй гэж Цэц үзсэн ч яагаад ингэж үзэж шийдвэрлэсэн үндэслэлээ ерөөсөө тайлбарлаж бичээгүй. Цэцийн энэ шийдвэр нь Үндсэн хуулийн зарчмаар зөвтгөгдөхгүй бөгөөд Үндсэн хуулийн холбогдох заалтыг буруу тайлбарласан юм. Ингээд Цэц ШИТЭЗБТХ-ийн амин сүнсийг нь үгүй хийж, 1992 оноос хойш өдийг хүртэл Үндсэн хууль дахь шүүхийн иргэдийн төлөөлөгчийн оролцооны заалтыг жинхэнэ агуулгаар нь хэрэгжүүлээгүй практикийг дахин сэргээж байна. Өөрөөр хэлбэл, шүүгчээр, цагдаагаар ажиллаж байгаад тэтгэвэртээ гарсан хөгшид,

³⁸ Leib, "A Comparison of Criminal Jury Decision Rules in Democratic Countries," 642.

шүүхийн үйлчилгээний ажилчид, дадлага хийж байгаа оюутнууд шүүхийн иргэдийн төлөөлөгчөөр нэр төдий орж дүгнэлтээ уншдаг практик үргэлжлэхээр болж байна.

Хэрэг, маргааныг анхан шатны журмаар бүрэлдэхүүнтэйгээр хянан шийдвэрлэх шүүх бүрэлдэхүүнд нэг иргэдийн төлөөлөгч мэргэжлийн хоёр шүүгчтэй хамт оролцох зохицуулалт нь Үндсэн хууль зөрчөөгүй. Харин ч энэ нь Үндсэн хуулийн 52.2-т "Анхан шатны шүүх хэрэг, маргааныг хамтран шийдвэрлэхдээ иргэдийн төлөөлөгчдийг хуульд заасан журмын дагуу оролцуулна" гэсэн заалтыг жинхэнэ утгаар нь хэрэгжүүлэх зорилготой байсан. Учир нь, шүүхийн иргэдийн төлөөлөгчийг хэрхэн оролцуулах вэ гэдгийг УИХ хуулиар шийдвэрлэхийг Үндсэн хууль өөрөө зөвшөөрсөн юм. Мөн, иргэдийн төлөөлөгч мэргэжлийн шүүгчтэй хамт шүүх бүрэлдэхүүнд оролцож хууль зүйн болон фактын асуудлыг шийдвэрлэснээр шүүхийн шийдвэр нь төрийн байгууллага, албан тушаалтан, улс төрч зэрэг аливаа этгээдийн зүй бус нөлөөгүйгээр илүү шударга, хүлээн зөвшөөрөгдөхүйц гарах нөхцөл бүрдэж, шударга шүүхээр шүүлгэх иргэний эрхийн нэгэн баталгаа болох байсан. Түүнчлэн, иргэдийн төлөөлөгч уул уурхай, бэлчээр, байгалийн бохирдол, гэр бүлийн хүчирхийлэл зэрэг нийтийн ашиг сонирхол, иргэдийн эрхийн асуудлыг шүүхээр шийдвэрлэхэд бодитой оролцох боломжтой болох байлаа. Энэ нь шүүхийн шийдвэр болон процессыг иргэд ойлгож мэдэхэд хялбар болгох, иргэний хууль зүйн боловсролыг дээшлүүлэх байсан. Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн бүрэн эрхийг хүчингүй болгосон Цэцийн шийдвэр нь Үндсэн хуулийн суурь зарчмуудыг зөрчөөд зогсохгүй шударга ёсыг тогтоох, хуулийн засаглалыг бэхжүүлэх, хүний эрхийн хамгаалалтыг сайжруулах, иргэний ардчилсан нийгмийг цогцлоон хөгжүүлэх нэг чухал механизмыг үгүй хийлээ.